

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2016 оны 07 дугаар сарын 19-ны өдөр

ИНЕГ нь Монгол Улсын Засгийн газрын “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2014 оны 387 дугаар тогтоолын дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай үйл ажиллагаагаа явуулж, харьяа төв, орон нутгийн 28 салбар байгууллагатай, нийт 2235 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнгөрсөн 4 жилд тус газрын хэмжээнд дараах томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Үүнд:

Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр

- “Иргэний нисэхийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Хууль, зүйн сайд, Зам, тээврийн сайд хамтран баталсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч “Тээврийн ерөнхий хууль”-ийн үзэл баримтлал, төсөлтэй уг хуулийн төслийг уялдуулан боловсруулах чиглэлийг ЗГХЭГ-аас өгөөд байна.
- “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 хүртэл баримтлах бодлого” -ыг УИХ-ын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлууллаа. Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2013 оны 428 дугаар тогтоолоор болон Зам, тээврийн сайдын 2014 оны 172 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Одоогоор 428 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний биелэлт 48%-тай, 172 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний биелэлт 29.6%-тай байна.
- Иргэний нисэхийн 62 багц дүрэм, Зөвлөмжийн цуврал байгаас 2012-2016 онд 2 дүрмийг шинээр, 11 дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан тус тус батлуулсан. 2016 онд 15 дүрмийг шинэчлэн боловсруулж Зам, тээврийн сайдын тушаалаар батлуулахаар бэлтгэсэн. Багц дүрмүүдийн зөвлөмжийн цуврал 43-ыг шинээр боловсруулсан.
- MNS 6409: 2013 “Иргэний нисэх. Ерөнхий нэр томъёо, тодорхойлолт” стандартыг 2013 оны 11 дүгээр сард, MNS 6478:2014 “Агаар ба газрын үйл ажиллагаанд хэрэглэх хэмжигдэхүүн болон нэгж” стандартыг 2014 оны 11 дүгээр сард, MNS 6591:2016 “Агаарын хөлгийн шатахууны чанарын хяналт ба сумалгаа хийх үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандартыг 2016 оны 5 дугаар сард Стандартын үндэсний зөвлөлөөр тус тус батлуулсан.
- Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн Хавсралт 17-д орсон өөрчлөлтийн дагуу Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрт нэмэлт шаардлагуудыг тусган, Засгийн газрын 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 128 дугаар тогтоолоор батлуулсан.
- Иргэний нисэхийн Аюулгүй ажиллагааны хөтөлбөр /“State Safety Programme”/ –ийг Зам, тээврийн сайдын 2016 оны 94 дүгээр тушаалаар батлууллаа.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрмийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2015 оны 258 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж байна.
- Агаарын харилцааны тухай хэлэлцээр БНБелУ, Мальта Улстай байгуулж, БНЭУ-тай байгуулсан хэлэлцээрийг шинэчилсэн. Шинээр 5 улстай Агаарын харилцааны хэлэлцээр байгуулахаар төслийг тохирч, 12 улстай нислэгийн цэг нэмэх, давтамж тохирох замаар агаарын харилцааг өргөжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүллээ.

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын чиглэлээр:

- Иргэний нисэхийн багц дүрмээр гэрчилгээжсэн гадаад дотоодын дараах нэгж байгууллага, мэргэжлийн ажилтан, агаарын хөлөгт аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны аудит хийж, хяналт тавьж ажилласан.
 - Хүчин төгөлдөр гэрчилгээжсэн аэродромын тоо-19;
 - Дотоодын Агаарын тээвэрлэгч байгууллагууд – 10;
 - Гадаадын Агаарын тээвэрлэгч байгууллагууд – 5;
 - Мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ эзэмшигч – 642;
 - Тээвэр зуучийн байгууллага – 6;
 - Иргэний нисэхийн сургалтын байгууллагууд – 29;
 - Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг – 27;
 - Шатахуун хангамжийн байгууллага – 3;
 - Техник үйлчилгээний байгууллага – 17;
 - Нисэхийн мэдээлэл хангалтын байгууллага – 1;
 - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага – 1;
 - Техник хангалт, радио навигацийн үйлчилгээний байгууллага – 1;
 - Нисэхийн аюулгүй байдлын байгууллага – 17;
 - Шалгалтын нислэг, зураглалын байгууллага – 1;
 - Нисэхийн цаг уурын байгууллага – 15;
 - Нисэх клуб – 1.
- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөр /COSCAP/-ийн хүрээнд Хойд Азийн бүсийн улс орнуудын Удирдах зөвлөлийн хурлыг 2013 онд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан.
- ICAO-ын нисэхийн аюулгүй байдлын Олон улсын аудитад 2015 оны 10 дугаар сарын 26-наас 30-ны өдрүүдэд шалгуулж, 95%-тай амжилтай дүгнэгдэв.
- Иргэний нисэхийн мэргэжлийн үнэмлэх эзэмшигчдээс авах онолын шалгалтыг Чикагогийн конвенцийн Хавсралт 1-д нийцүүлэх, хувь хүний мэдлэг ур чадварын үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор Шинэ Зеланд Улсын “Аспек” ХК-тай хамтран мэргэжлийн шалгалтыг онлайнаар авах гэрээг 2016 оны 6 сард байгуулсан бөгөөд энэ оны 10 сараас хэрэгжиж эхлэнэ.
- Чикагогийн конвенцийн Хавсралт 1-д тогтоосон 4 дүгээр түвшний англи хэлний шаардлагыг Монгол Улсын олон улсын нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэгч, нислэгийн удирдагчид бүрэн хангасан тухай мэдээллийг 2014 онд ICAO-д хүргүүлсэн.
- Ази-Номхон далайн нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Ачаа шуудангийн аюулгүй байдал” сэдэвт олон улсын семинарыг 2016 оны 5 сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан.
- Монгол Улсад ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Айдасыг давах” нэг сарын аянг 2016 оны 1 сард зохион байгуулж, нислэгийн төлөвлөлт, эрх зөвшөөрөл олгох үйл ажиллагаа дахь дүрмийн бус шаардлага, заавар журмууд, үйл ажиллагааг хүчингүй болгох, хялбаршуулах зэрэг зохицуулалтыг хийсэн.
- 2016 оны 3 дугаар сард Иргэний нисэхийн салбарын нэгж байгууллагуудын удирдлага, дотоод чанар баталгаажуулалтын менежерүүд дунд “Чанарын удирдлагын тогтолцоо” сэдэвт зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулсан.
- Хяналтын байцаагч нарын Сургалтын хөтөлбөрийг 2016 оны 4 сард боловсруулж, ICAO-гийн зааврын шаардлагад нийцүүлсэн.

Агаарын хөлөгтэй холбоотой осол, зөрчлийн тоо

Д/Д	Он	Осол	Ноцтой зөрчил	Зөрчил
1	2012	-	1	18
2	2013	-	1	12
3	2014	1	2	16
4	2015	-	4	15

Жич : Тайлант жилүүдэд хүний амь настай холбоотой осол зөрчил гараагүй болно.

Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын чиглэлээр:

- Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Беларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төслийг бэлтгэн, бэлтгэл ажлыг хангаж 2014 оны 9 дүгээр сард байгуулсан. Хэлэлцээрийг Засгийн газрын 2015 оны 179 дүгээр тогтоолоор батлуулсан.
- Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын 1998 онд байгуулсан хэлэлцээрийг шинэчлэх бэлтгэл ажлыг хангаж, 2015 оны 5 дугаар сард байгуулсан. Хэлэлцээрийг Засгийн газрын 2015 оны 276 дугаар тогтоолоор батлуулсан.
- Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Мальт Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах бэлтгэл ажлыг хангаж, хэлэлцээрийг 2016 оны 7 дугаар сарын 13-нд байгуулсан.
- Агаарын харилцааны тухай хэлэлцээр Мьянмар, БНЧУ, Азербайжан, Камбож улсуудтай шинээр байгуулахаар, Люксембургийн талтай шинэчилж байгуулахаар тус тус төслийг тохирч үзэглэсэн. Швейцарийн Холбооны Улстай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулан тохирч, баталгаажуулсан.
- Нислэгийн цэг, давтамж нэмэх, аялалын дугаар хуваан ашиглах зохицуулалт тохирох замаар 12 улстай агаарын харилцааг өргөжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүллээ. Монголын талаас шинээр 8 нислэгийн чиглэл нээж, нислэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн. Гадаадын 3 агаарын тээврийн компани 4 чиглэлээс нислэг гүйцэтгэж эхэлсэн.
- Агаарын хөлгийн шатахууны татварыг чөлөөлүүлэх талаарх тооцоо судалгаа хийж, Засгийн газрын 2014 оны 140 дүгээр тогтоолоор Сүхбаатар, Замын-Үүдийн боомтоор импортолсон агаарын хөлгийн шатахууны гаалийн албан татварыг "0" хувиар тогтоолгон шийдвэрлүүлсэн.
- Агаарын тээврийн үйлчилгээг алслагдсан бүс нутгийн иргэдэд хүргэх зорилгоор нөхөн олговор олгох нөхцөлтэйгөөр Ховд- Ховдын Булган – Ховд, Улаанбаатар - Доной – Тосонцэнгэл, Улаанбаатар – Баруун-Урт - Улаанбаатарын чиглэлд 2013-2014 онд, Ховдын чиглэлд 2016 оны 4-6 дугаар сард нислэг гүйцэтгүүлсэн.
- Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга, байгууламжийг барьж ашиглалтад оруулах, мөн Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд баригдах "Ангарын барилга байгууламж"-ийн ажлыг Засгийн газрын 2016 оны 149 дүгээр тогтоолоор "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулсан.

Агаарын навигацгийн үйлчилгээний чиглэлээр:

- Агаарын зайн зохион байгуулалтыг сайжруулах, агаарын навигацгийн үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд шинээр 2 агаарын хаалга нээсэн. Монгол Улс нийтдээ 15 агаарын хаалга, 13 агаарын замыг ашиглаж байна.
- Монгол Улсын агаарын зайд харж удирдах радарын системийг нэвтрүүлснээр нислэг үйлдэж буй агаарын хөлгүүдийн хоорондын зайчлал 150 км байсныг 30 км

зайчлалд 2015 оны 3 сараас шилжүүлсэн. Үүний үр дүнд 2015 онд өнгөрөлтийн нислэгийн тоо 4.3 хувиар нэмэгдэж байна. Өнгөрөлтийн нислэгийн тоо 2016 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 7 хувийн өсөлттэй байна.

- *Үзүүлэлтэд тулгуурласан навигацийг (PBN) хэрэгжүүлж байна.* Орчин үед агаарын хөлгийн чадамж, навигацийн тоноглол өндөр хэмжээнд хүрч, хиймэл дагуулын системийг бүрэн ашиглах болсон. Олон улсын агаарын замуудад үзүүлэлтэд тулгуурласан навигаци хэрэгжүүлэх үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлж байна.
- *Автомат хамааралтай ажиглалтын (ADS-B) системийг нэвтрүүлсэн.* Уг систем нь хямд өртгөөр босдог, овор хэмжээ жижиг, угсралт суурилуулалтын ажиллагаа хялбар, гол давуу тал нь радио локатортай адил агаарын хөлгийн байрлалын мэдээллийг дэлгэцэн дээр үзүүлдэг. Энэхүү орчин үеийн дэвшилтэд технологийг Монгол Улсын иргэний нисэхийн салбарт 2015 оноос эхлэн үйл ажиллагаанд туршилтаар ашиглаж эхэлсэн. Одоогийн байдлаар нийт 9 ADS-B системийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын дээд агаарын зайн (6150 м ээс дээш) нь 90 гаруй хувийг бүрхэж байна.
- *Хиймэл дагуулын холбооны шинэчлэл.* Сансрын холбооны VSAT системийг агаарын навигацийн үйлчилгээний үндсэн дамжуулах байгууламжаар 1997 оноос хойш ашиглагдаж байна. 2015 онд тус газрын инженер техникийн ажилтнууд интернэт технологид суурилсан сансрын холбооны сүлжээний загварчлалыг боловсруулан амжилттай хэрэгжүүллээ. Энэ ажлыг гүйцэтгэснээр 240 орчим сая төгрөг хэмнэж, Монгол Улсыг хамарсан сансрын холбооны шинэ технологи бүхий сүлжээг агаарын навигацийн үйлчилгээний үндсэн дамжуулах байгууламжид зориулан технологи үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлсэн.

Нисэх буудлын үйл ажиллагааны чиглэлээр:

- “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Мицубиши, Чиёда” компани шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулж, барилгын ажлыг 2013 оны 6 дугаар сараас эхлүүлсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 81.1%-тай, төлөвлөснөөс 5.9%-иар түрүүлж хэрэгжиж байна.
- Олон улсын шинэ нисэх буудлын менежментийг ижил төстэй үйл ажиллагааны туршлага бүхий байгууллагаар концессоор гүйцэтгүүлэхээр Засгийн газрын 2015 оны 398 дугаар тогтоолоор шийдвэрлэсний дагуу Ерөнхий сайдын 2016 оны 80 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсэг нь “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент” төслийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдүүдтэй хэлэлцээ хийх шатанд ажиллаж байна.
- Говь-алтай аймгийн Алтай хотын нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас барих ажлыг үргэлжлүүлэн, 2016 оны 5 дугаар сарын 31-нийн өдрөөс барилгын ажлыг эхлүүлэн хийж байна.
- “Чингис хаан” олон улсын нисэх буудлын нэгдүгээр давхрын олон улс, орон нутгийн чиглэлээс ирэх зорчигчдод үйлчлэх талбайг нэгтгэн, өргөтгөсөн. Мөн нисэх буудлын олон улсын ирэгчдийн танхимд өмнөхөөсөө хоёр дахин хурдтай ачаа тээшний шинэ дамжуулагчийг ашиглалтад орууллаа.
- АСЕМ-ыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд шинээр транзит заал байгуулж, ашиглалтад хүлээн авсан. Перроны талбайд өргөтгөл хийж, дунд оврын 9 ширхэг агаарын хөлгийн зогсоол барих, хөөрч буух зурвасын 500 м бетон хэсгийн хүчитгэл, явгалах замын хүчитгэлийг хийсэн.

Монгол Улсын эдийн засагт оруулсан хувь нэмэр:

Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх өнгөрөлтийн нислэгийн тоо 2015 онд 90.7 мянгад хүрч, сүүлийн 5 жилд дунджаар 4.1 хувиар өссөн байна

Өнгөрөлтийн нислэгийн навигацийн үйлчилгээний орлогоос Улсын төсөвт татварын бус орлого буюу өнгөрөлтийн орлогоос 2011 онд 40.8 тэрбум төгрөг буюу 52 хувийг төвлөрүүлж байсан бол 2015 онд 98.5 тэрбум төгрөг буюу 61 хувийг төвлөрүүлсэн.

Он	Өнгөрөлтийн нислэгийн тоо	Өсөлтийн хувь	Навигацийн орлого /тэрбум.төг/	Төсөвт төвлөрүүлсэн орлого /тэрбум төг/
2012	82626		96.8	45.2
2013	85690	3.7	116.9	63.3
2014	87117	1.7	144.5	73.2
2015	90686	4.1	163.3	98.5
2016	95220	5.0	186.6	137.9 /төлөвлөсөн/

Иргэний нисэхийн ерөнхий газрын эдийн засгийн үзүүлэлт

Он	Улсын төсөв-шилжих	Улсын төсөв	ИНЕГ-ын Цэвэр ашиг	Нийт
2012 он	28.136.8	7.000.0	1.150.0	36.286.80
2013 он	5.912.4	27.659.0	4.778.7	38.350.09
2014 он	15.921.7	5.000.0	3.247.7	24.169.39
2015 он	2.292.6	-	23.716.4	26.009.00
2016 он	1.135.1	13.500.0	4.900.0	19.535.10

Орлогын үзүүлэлт:

№	Орлогын үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
1	Өнгөрөлт	96.818.7	116.942.7	144.521.5	163.309.6	186.646.5
2	Буулт, хөөрөлт	6.945.6	7.958.8	9.620.7	9.483.9	8.978.9
3	Зорчигч үйлчилгээ	7.770.2	9.475.9	9.176.2	9.042.0	8.803.8
4	Шатахуун					2.000.0
5	Бусад	12.057.5	17.515.3	15.442.7	14.708.8	15.400.0
	Нийт	123.592.0	151.892.7	178.761.1	196.544.3	221.829.2

Шийдвэрлэх асуудлууд:

- Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Тээврийн ерөнхий хуультай уялдуулан эцэслэн боловсруулж, УИХ-аар батлуулах;
- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчлэлтэд нийцүүлэн “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Засгийн газрын “Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай” 2015 оны 129 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, 'ИНЕГ-ын үйл ажиллагааг үйлдвэрлэл, үйлчилгээний болон хяналт, зохицуулалтын гэсэн чиглэлээр тусгаарлах бүтцийн өөрчлөлтийн концепцийг Иргэний нисэхийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж, бүтцийн өөрчлөлтийг хөтөлбөр гарган хэрэгжүүлэх;
- Ерөнхий зориулалтын нисэхийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;
- Завхан аймгийн Донойн нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг барьж дуусгах;

- Шинэ нисэх буудлын газрын навигацийн тоног төхөөрөмжийн шалгалтын нислэгийн зардал 850.0 сая төгрөгийг өөрийн орлогоос санхүүжилт хийх тул төсөвт суулгах;
- Шинэ нисэх буудлын нутаг дэвсгэрийг оролцуулсан “Чөлөөт бүс” байгуулах асуудлыг шийдвэрлүүлэх;
- Орон нутгийн агаарын тээврийг сэргээн тогтворжуулах, агаарын тээврийн үнэ тарифыг бууруулах талаар эдийн засгийн зохистой арга хэмжээ авах /татварын бодлогоор дэмжих, татаас олгох зэрэг/;
- 2016 оны Улсын төсөвт 124.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр /валютын ханшийг 2030 төгрөгөөр, өнгөрөлтийн нислэгийн тоог өмнөх оноос 5 хувиар нэмэгдүүлэн тооцоолсон/ тусгасан. Төсөвт төвлөрүүлэх орлогоос 13,5 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад тусгуулах санал хүргүүлсэн боловч нэмэгдүүлэн суулгасан. Иймд илүү тусгагдсан 13.5 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэх орлогоос хасуулах;
- 2016 оны 6 сарын байдлаар гадаад валютын бодит ханшийн зөрүүгийн алдагдал 1.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнийг төсөвт төвлөрүүлэх орлогоос бууруулах;
- Шинэ нисэх буудлын ажилчдын нийгмийн асуудлыг хангах шаардлагын үүднээс орон сууцны зардалд 20.0 тэрбум төгрөгийг 2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах;
- 2016 оны цалингийн зардалд ажилтнуудын үр дүнгийн урамшуулал, зэргийн нэмэгдэл, татвар нийгмийн даатгалын шимтгэлд шаардлагатай 539.8 сая төгрөгийг цалингийн зардалд нэмэгдүүлэх.

Тулгамдсан асуудал:

- Шинэ нисэх буудлыг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах талаар Монгол Улсын Засгийн газраас бүтээн байгуулалтын асуудлаар шийд гаргаж, тэдгээрийн санхүүжилтийг шийдвэрлэх.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

7 дугаар хуудсыг Солонго өгнө


2012-2016 оны нислэгийн чиглэлийн тоон үзүүлэлт

Нислэгийн чиглэл	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 оны II улирал
Олон улсын чиглэлд	9 агаарын тээвэрлэгч 13 чиглэлд	8 агаарын тээвэрлэгч 14 чиглэлд	7 агаарын тээвэрлэгч 17 чиглэлд	8 агаарын тээвэрлэгч 15 чиглэлд	8 агаарын тээвэрлэгч 15 чиглэлд
Орон нутгий чиглэлд	3 агаарын тээвэрлэгч 18 чиглэлд	3 агаарын тээвэрлэгч 17 чиглэлд	4 агаарын тээвэрлэгч 16 чиглэлд	3 агаарын тээвэрлэгч 14 чиглэлд	3 агаарын тээвэрлэгч 11 чиглэлд


2012-2016 онд шинээр нээсэн нислэгийн чиглэл:

- “МИАТ” ТӨХК нь 2014 оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс Улаанбаатар-Франкфурт-Улаанбаатарын чиглэлд нислэг нээж, зуны улиралд нислэг гүйцэтгэж байна.
- “МИАТ” ХК нь 2014 оны 09 дүгээр сарын 24-нөөс эхлэн Улаанбаатар-Бээжин-Сингапур-Улаанбаатарын чиглэлд нислэг үйлдэж эхэлсэн.
- “Хүннү Эйр” ХХК нь 2014 оны 09 дүгээр сараас Хайлаар, Манжуурын чиглэлд нислэг үйлдэж эхэлсэн.
- ОХУ-ын “Ир Аеро” ООО нь Улан-Удэ-Улаанбаатар-Улан-Удэ чиглэлд 2015 оны 10 дугаар сарын 09-нөөс нислэг үйлдэж эхэлсэн.
- БНСУ-ын “Эйр Бусан” компани нь Бусан-Улаанбаатар-Бусан чиглэлд 2016 оны 6 дугаар сарын 24-нөөс нислэг үйлдэж эхэлсэн.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх агаарын хаалга, агаарын зам



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЗОРИУЛАЛТТАЙ НИСЭХ БУУДУУДЫН МЭДЭЭЛЭЛ



№	Нисэхийн нэр	Сэтгүүл, үйлчилгээний байр	Төрөл	НБ	Төсвийн төрөл	Хувийн эзэмшлэл	Хувийн эзэмшлэл (%)
1	Дэлгэр	Дэлгэр	Хувийн	1	Хувийн	100%	100%
2	Дорнод	Дорнод	Хувийн	1	Хувийн	100%	100%
3	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
4	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
5	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
6	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
7	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
8	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
9	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
10	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
11	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
12	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
13	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
14	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
15	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
16	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
17	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
18	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
19	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
20	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%
21	Дундговь	Дундговь	Хувийн	1	Хувийн	100%	100%

- ОУ-ин 4D ангиллыг эзрөлдөмтөг нисэх буудал
- ЗС ангиллыг эзрөлдөмтөг нисэх буудал (Хөвч бүүх цементтөвөг дүнчилтэй)
- ЗС ангиллыг эзрөлдөмтөг нисэх буудал (Хөвч бүүх асралт-бэлтэг дүнчилтэй)
- Хөвч бүүх шороон зурвастай нисэх буудал

Төрөөс иргэдийн нисэхийн салварт 2020 он хүртэл барилгаж бодлогын 6.1.4 заалтын хүрээнд Дорнод, Дундговь, Хөвд, Чойбалсан хотын нисэх буудлыг олон улсын 4D (Бонг 767-300) ангиллын нисэх буудал болгоно.

Төрөөс иргэдийн нисэхийн салварт 2020 он хүртэл барилгаж бодлогын 6.1.2 заалтын хүрээнд Хөвд, Чойбалсан хотын нисэх буудлыг хагас дүнчилтэй зурвас дүнчилтэй хийж өргөтгөж, олон улсын 4С (Бонг 737-800) ангиллын нисэх буудал болгоно.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Иргэний нисэхийн ерөнхий газрын эдийн засгийн үзүүлэлт

Он	Улсын төсөв-шилжих	Улсын төсөв	ИНЕГ-ын Цэвэр ашиг	Нийт
2012 он	28.136.8	7.000.0	1.150.0	36.286.80
2013 он	5.912.4	27.659.0	4.778.7	38.350.09
2014 он	15.921.7	5.000.0	3.247.7	24.169.39
2015 он	2.292.6	-	23.716.4	26.009.00
2016 он	1.135.1	13.500.0	4.900.0	19.535.10

